Төсөвт байгууллагууд энэ сард 36.8 сая төгрөгийн авлага шинээр үүсгэж, 3.2 сая төгрөгийн авлагыг барагдуулан сарын эцэст 425.0 сая төгрөгийн авлагатай үлджээ.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ



Нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 2014 оны эхний 3 сард 19.1 мянган байгууллагын 414.3 мянга гаруй хүн хамрагдаж шимтгэл төлжээ. Тэдгээрийн 83.8 мянга буюу 20.2 хувь нь төсөвт байгууллагын, 279.5 мянга буюу 67.5 хувь нь бусад өмчийн аж ахуйн нэгж байгууллагын, 51.0 мянга буюу 12.3 хувь нь сайн дурын даатгуулагчид байна.

Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар буюу 43.2 мянган хүнээр нэмэгджээ.




Зураг 24. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 88.1 хувиар биелүүлж, даатгалын санд нийт 156.3 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.7 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 18.8 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.2 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.6 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 1.7 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 25. Даатгалын сангийн зарлага



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас эхний 3 сард даатгуулагч, иргэдэд 186.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон байна.

Нийт зардлын 69.2 хувийг тэтгэврийн, 15.0 хувийг эрүүл мэндийн, 6.7 хувийг ҮОМШӨ-ний, 6.7 хувийг тэтгэмжийн, 2.2 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 3-р сард 129.5 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 105.1 тэрбум төгрөгт хүрчээ.

Олгосон нийт тэтгэврийн 73.2 хувийг өндөр насны, 10.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.9 хувийг тэжээгчээ алдсаны, 12.8 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.





ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2014 оны 3 дугаар сарын эцэст 11526 болж, өмнөх оны мөн үеэс 4.2 хувь буюу 501 хүнээр буурчээ. Нийт ажилгүйчүүдийн 5852 буюу 50.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 29.5 хувь буюу 3404 нь 15-24 насны, 35.2 хувь буюу 4056 нь 25-34 насны, 18.2 хувь буюу 2099 нь 35-44 насны, 17.1 хувь буюу 1967 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Хүснэгт 23. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /4-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2012 он	2013 он	2014 он	2012 он	2013 он	2014 он
Нийт ажилгүйчүүд	17993	12027	11526	100	100	100
Үүнээс : дээд боловсрол	7119	3967	4208	39.6	33.0	36.5
Тусгай дунд боловсрол	1160	954	1160	6.5	7.9	10.1
Мэргэжлийн анхан шатны боловсрол	1285	889	647	7.1	7.4	5.6
Ерөнхий боловсрол	8333	6155	5459	46.3	51.2	47.4
Мэргэжилгүй	96	62	52	0.5	0.5	0.4

Зураг 26. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 20.3 хувь буюу 2342 нь Баянзүрх, 19.0 хувь буюу 2190 нь Сонгинохайрхан, 13.1 хувь буюу 1506 нь Чингэлтэй, 13.0 хувь буюу 1493 нь Баянгол, 11.7 хувь буюу 1348 нь Сүхбаатар, 11.3 хувь буюу 1306 нь Хан-Уул, 8.7 хувь буюу 1001 нь Налайх, 2.2 хувь буюу 256 нь Багануур, 0.7 хувь буюу 84 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Нийслэлийн 9 дүүргийн хөдөлмөрийн хэлтэст 2014 оны эхний 3 сард 7678 хүн ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 15.0 хувь буюу 1002 хүнээр өсчээ. Дүүргийн хөдөлмөрийн хэлтсүүдээр зуучлуулан 1714 хүн 2014 оны эхний улиралд ажилд оржээ. Эдгээр хүмүүсийн 1.6 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 10.2 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 88.2 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд орсон байна.

2014 оны 3-р сард ажилгүй 3097 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 874 иргэн ажилд зуучлагдан орж, 2449 иргэн бүртгэлээс хасагджээ.





ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Эрүүл мэндийн яамны захиргааны статистикийн мэдээллээр 2014 оны эхний 3 сард 9832 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 567 хүүхдээр олон байна. Нийт төрсөн хүүхдийн 14.3 хувь буюу 1410 нь бусад аймгийн харьяат эхчүүдээс төрсөн байна.

Хүснэгт 24. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл

	2012 он	2013 он	2014 он	$\frac{2014}{2013} \%$
Амаржсан эхийн тоо	8348	9215	9740	105.7
Амьд төрсөн хүүхэд	8393	9265	9832	106.1
Эхийн эндэгдэл	5	4	4	100.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	104	139	154	110.8
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	12.39	15.00	15.66	104.4

Нялхсын эндэгдлийн 22.4 хувь буюу 26 нь Баянзүрх, 20.7 хувь буюу 24 нь Сонгинохайрхан, 14.7 хувь буюу 17 нь Баянгол, 13.8 хувь буюу 16 нь Чингэлтэй, 12.9 хувь буюу 15 нь Хан-Уул, 6.0 хувь буюу 7 нь Сүхбаатар, 4.3 хувь буюу 5 нь Налайх, 3.5 хувь буюу 4 нь Багануур, 1.7 хувь буюу 2 нь Багахангай дүүрэгт тус тус гарсан байна. Нялхсын эндэгдлийн 24.0 хувь буюу 37 нь бусад аймгийн харьяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 0.66 промилээр өсчээ.

Зураг 27. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 23.8 хувийг тэмбүү, 17.0 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 16.4 хувийг салхин-цэцэг, 10.8 хувийг трихомониаз, 9.4 хувийг заг хүйтэн, 5.7 хувийг гар хөл амны өвчин, 5.0 хувийг цусан суулга, 3.3 хувийг вируст хепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Нийслэлд 2014 оны эхний 3 сард 3955 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 11.0 хувь буюу 489 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 4.8 продицимилээр тус тус буурчээ.



Хүснэгт 25. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 3 сард

	хэмжих нэгж	2013 он	2014 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	4444	3955	- 489	- 11.0
	10000 хүнд	36.52	31.72	- 4.80	
Вируст гепатит	бодит тоо	416	130	- 286	- 3.2 дах
	10000 хүнд	3.42	1.04	- 2.38	
Менингит	бодит тоо	10	2	- 8	- 5.0 дах
	10000 хүнд	0.08	0.02	- 0.06	
Цусан суулга	бодит тоо	186	197	11	5.9
	10000 хүнд	1.53	1.58	0.05	
Салхин цэцэг	бодит тоо	715	650	- 65	- 9.1
	10000 хүнд	5.88	5.21	- 0.67	
Гахай хавдар	бодит тоо	569	59	- 510	- 9.6 дах
	10000 хүнд	4.68	0.47	- 4.21	
Сальмонеллөз	бодит тоо	4	4	-	-
	10000 хүнд	0.03	0.03	-	
Улаан эсэргэнэ	бодит тоо	50	52	2	4.0
	10000 хүнд	0.41	0.42	0.01	
Хоолны хордлого	бодит тоо	18	23	5	27.8
	10000 хүнд	0.15	0.18	0.03	
Ёлом	бодит тоо	21	14	- 7	- 33.3
	10000 хүнд	0.17	0.11	- 0.06	
Бруцеллөз	бодит тоо	2	6	4	3.0 дах
	10000 хүнд	0.02	0.05	0.03	
Нярайн халдвар	бодит тоо	-	2	2	-
	10000 хүнд	-	0.02	0.02	
Гар хөл амны өвчин	бодит тоо	47	225	178	4.8 дах
	10000 хүнд	0.39	0.80	0.41	
Тэмбүү	бодит тоо	849	943	94	11.1
	10000 хүнд	6.98	7.56	0.58	
Заг хүйтэн	бодит тоо	424	372	- 52	- 12.3
	10000 хүнд	3.48	2.98	- 0.5	
Трихомониаз	бодит тоо	486	429	- 57	- 11.7
	10000 хүнд	3.99	3.44	- 0.55	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	571	672	101	17.7
	10000 хүнд	4.69	5.39	0.7	
ДОХ	бодит тоо	4	8	4	2.0 дах
	10000 хүнд	0.03	0.06	0.03	





НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн Тээврийн газраас Улаанбаатар хотын дотор болон хот орчимд 2014 оны эхний 3 сард 4.5 мянган км урт бүхий нийт 146 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулжээ.

Нийтийн тээврийн үйлчилгээнд 2014 оны эхний 3 сард үндсэн чиглэлд шинээр 4 чиглэл нэмэгдсэн байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2014 оны эхний 3 сард 244.1 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн 71.8 сая хүн тээвэрлэж, 26.7 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна. Өнгөрсөн оны мөн үеэс зорчигчийн тоо 4.2 хувиар буюу 2.9 сая хүнээр, үйлчилгээний орлого 7.2 хувиар буюу 1.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 28. Зорчигч тээврийн чиглэлийн тоо



Зураг 29. Зорчигч тээврийн чиглэлийн урт



Зураг 30. Зорчигч тээврийн үйлчилгээний ААН-ийн тоо



Улаанбаатар хотод 2014 оны эхний 3 сард 66 аж ахуйн нэгж нийтийн тээврийн үйлчилгээг эрхэлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 9 аж ахуйн нэгжээр цөөрсөн байна.

Хувийн хэвшлийн их, дунд багтаамжийн автобусны болон такси үйлчилгээний аж ахуйн нэгж тус бүр 1-ээр нэмэгдэж, харин бага багтаамжийн ААН-ийн тоо 11-ээр буюу 31.4 хувиар буурчээ. 2014 оны эхний 3 сард бүрдүүлсэн үйлчилгээний нийт орлогын 41.5 хувийг шугамын орлого, 58.5 хувийг нөхөн олговор эзэлж байна.




Нийтийн тээврээр зорчигчдын 45.6 хувь нь зорчих тасалбар худалдан авч, харин 54.4 хувь нь нөхөн олговроор үйлчлүүлжээ. Өөрөөр хэлбэл нийтийн тээврийн хэрэгслээр 2014 оны эхний 3 сард давхардсан тоогоор 39.1 сая зорчигч үнэ төлбөргүй үйлчлүүлж, төрөөс эдгээр хүмүүсийн үйлчилгээний 15.6 тэрбум төгрөгийн төлбөрийг нөхөн олговор хэлбэрээр аж ахуйн нэгжүүдэд шилжүүлсэн байна.

Хүснэгт 26. Нийтийн тээврийн үйлчилгээ, төлбөрийн хэлбэрээр, 2014 оны эхний 3 сард


Тээврийн хэрэгсэл, төрөл, өмчлөлөөр	Аж ахуйн нэгж, тоо	Тээврийн хэрэгсэл, тоо	Орлого, тэрбум төгрөг	Үүнээс:		Зорчигч, сая хүн	Үүнээс:	
				зорчих тасал-бараар	нөхөн олгов-роор		зорчих тасал-бараар	нөхөн олгов-роор
Автобус (ТӨК)	2	250	7.8	3.6	4.2	22.6	12.1	10.5
Троллейбус (ТӨК)	1	55	0.8	0.3	0.5	2.9	1.5	1.4
Автобус (хувийн)	21	870	16.4	5.7	10.7	42.2	15.5	26.7
Троллейбус (хувийн)	1	15	0.3	0.08	0.18	0.77	0.33	0.44
Микроавтобус	24	772	1.4	1.4	0.04	3.3	3.2	0.1
Дүн	49	1962	26.7	11.08	15.62	71.8	32.63	39.14

2014 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн нийтийн тээврийн үйлчилгээний хот доторх үндсэн чиглэлд болон их, дунд багтаамжийн автобусаар үйлчилгээ үзүүлдэг хот орчмын чиглэлд насанд хүрэгчдийн зорчих тариф 100 төгрөгөөр нэмэгдэж, их, дунд багтаамжийн болон туслах чиглэлийн бага оврын автобусаар 500 төгрөг, троллейбусаар 300 төгрөг, буухиа чиглэлд 400-600 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусаар 500-2300 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна.

Зураг 31. Зорчигчдын тоо, сая хүн, төлбөрийн хэлбэрээр



Зураг 32. Үйлчилгээний орлого, тэрбум төгрөг, төлбөрийн хэлбэрээр



Хүснэгт 27. Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний тоо

Дансны хөдлөх бүрэлдэхүүн		2013 оны эхний 3 сар	2014 оны эхний 3 сар
Бүгд		2870	2689
Их, дунд багтаамжийн автобус	Төрийн өмч	252	250
	Хувийн өмч	793	870
Бага багтаамжийн автобус (хувийн)	Туслах чиглэл	476	358
	Буухиа чиглэл	555	414
Троллейбус	Төрийн	44	55
	Хувийн	15	15
Такси		735	727


Нийслэл хотод нийтийн зорчигч тээврийн зориулалтын 2689 хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлтэй байна. Эдгээрийн 28.7 хувь нь бага багтаамжийн автобус, 41.6 хувь нь их, дунд багтаамжийн автобус, 27.0 хувь нь такси байна. 2014 оны эхний 3 сард нийтийн тээврийн парк шинэчлэлтээр их багтаамжийн 69 автобус, 30 такси, 4 троллейбус үйлчилгээнд шинээр нэмэгдэж, стандартын шаардлага хангахгүй болж 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 169 тээврийн хэрэгсэл (их, дунд багтаамжийн хувийн 1 автобус, бага багтаамжийн 144 автобус, 24 такси) үйлчилгээнээс хасагдсан байна.

2014 оны эхний 3 сард өдөрт дунджаар их, дунд багтаамжийн 800 автобус, 40 троллейбус, бага багтаамжийн 610 автобус, 582 такси, хот орчмын чиглэлд 75 тээврийн хэрэгсэл нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллажээ.

Зураг 33. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл, тоо



Зураг 34. Хүлээлтийн хугацаа, минут



Улаанбаатар хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилгоор зарим замуудад хязгаарлалтын бүс тогтоож, тээврийн хэрэгслийг улсын бүртгэлийн дугаараар нь ангилан явуулах зэрэг зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч нийтийн тээврийн үйлчилгээний “үндсэн чиглэл”-ийн хүлээлтийн хугацаанд эерэг өөрчлөлт төдийлөн гарахгүй байна.




Тухайлбал, зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу хүлээлтийн дундаж хугацааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бага оврын автобусных 0.6 минутаар, их, дунд багтаамжийн автобусных 1.1 минутаар, цахилгаан тээврийн хүлээлтийн хугацаа 1.6 минутаар тус тус нэмэгджээ.

Нийслэлийн Тээврийн газарт 2014 оны эхний 3 сард зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс дараах төрлийн нийт 492 санал, гомдол ирүүлсний 94.5 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна.

Зураг 35. Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх санал, гомдол, 2014 оны эхний 3 сар



Зураг 36. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал, гомдлын шийдвэрлэлт





ХАРИЛЦАА ХОЛБОО

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2014 оны эхний 3 сард 163.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 35.0 тэрбум төгрөгөөр буюу 27.3 хувиар өсчээ. Нийт орлогын 71.5 хувь буюу 116.5 тэрбум төгрөгийг нийслэл хотын хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.

Хүснэгт 28. Холбооны салбарын үндсэн үзүүлэлт

	Хэмжих нэгж	2013 оны эхний 3 сар	2014 оны эхний 3 сар
Нийт орлого	сая төг	128011.0	163019.5
Үүнээс: хүн амаас	сая төг	100359.0	116564.1
Суурин телефон цэг	тоо	115426	166555
Үүнээс: айл өрхийн	тоо	83493	136969
Утасгүй телефон	тоо	3578	576
Үүрэн телефон хэрэглэгч	мянган хүн	1971.0	1740.2
КаТВ-ийн хэрэглэгч	тоо	217741	250109

2014 оны эхний 3 сард нийслэлийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 166.5 мянга болж, өмнөх онтой харьцуулахад 44.3 хувиар нэмэгджээ.

Нийт суурин телефон цэгийн 137.0 мянга буюу 82.2 хувийг айл өрх ашиглаж байна.

Өрхийн суурин телефон цэгийн тоо 2013 оны мөн үеэс 64.0 хувиар өссөн нь гурвалсан үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгч өрхийн тоо нийслэлд нэмэгдэж байгаатай холбоотой.


2014 оны эхний 3 сард Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.5 сая гаруй хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 49.2 хувь буюу 1.7 сая гаруй хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үүрэн телефон хэрэглэгчийн тоо нийслэлд 230.8 мянгаар буурсан. Энэ нь үүрэн оператор компаниуд бүртгэлтэй нийт хэрэглэгчдээс идэвхтэй хэрэглэгчдийн тоог орон нутгийн харьяаллаар нь салгаж хэрэглэгчдийнхээ дүн мэдээг гаргах болсонтой холбоотой юм.

Монгол Улсын хэмжээнд 2014 оны эхний 3 сард давхардсан тоогоор нийт 3.5 сая гаруй хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 49.2 хувь буюу 1.7 сая гаруй хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үүрэн телефон хэрэглэгчийн тоо нийслэлд 230.8 мянгаар буурсан. Энэ нь үүрэн оператор компаниуд бүртгэлтэй нийт хэрэглэгчдээс идэвхтэй хэрэглэгчдийн тоог орон нутгийн харьяаллаар нь салгаж хэрэглэгчдийнхээ дүн мэдээг гаргах болсонтой холбоотой юм.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 284.2 мянга орчим нь дараа төлбөрт үйлчилгээний, 1456.0 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. Хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 0.6 мянга болж 2013 оны мөн үеэс эрс буурсан нь F-zone үйлчилгээний хэрэглэгчдийг CDMA болон GSM системд шилжүүлэх зохицуулалтын арга хэмжээ авснаас шалтгаалсан байна. Нийслэлд 0.1 мянган хэрэглэгч сансарын холбоог эзэмшдэг байна.



Зураг 37. Суурин телефон цэгийн тоо




Зураг 38. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо



Гурвалсан үйлчилгээнээс бусад кабелийн телевизийн сувагт холбогдох шинэ тавилтын үнэ нийслэлийн төвийн 6 дүүргийн айл өрхөд 10.0-99.0 мянган төгрөгийн хооронд байхад үйлчилгээний төлбөрийн сарын хураамж өрхөд 4000-9900 төгрөгийн тарифтай байв.

Зураг 39. КаТВ, сувагт холбогдсон хэрэглэгчийн тоо



Кабелийн болон Ай Пи телевизийн 19 аж ахуйн нэгж байгууллага нийслэлийн 250.1 мянган хэрэглэгчдэд үйлчилж байна.

Кабелийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн 93.7 хувийг айл өрх эзэлдэг байна.

Кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн 16 нь нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж, хоногт дунджаар 50-130 гаруй сувгаар үйлчилгээ хүргэж байна. Нийслэлийн Налайх, Багануур дүүргийн хэрэглэгчид 3 аж ахуйн нэгжийн үйлчилгээг 34-55 хүртэл сувгаар хүлээн авчээ.



АМЬДАРЧ БҮЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж температур 2014 оны 3 сард дунджаар -4.7°C байв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1.6°C -аар, олон жилийн дундажтай харьцуулахад 3.0°C -аар дулаан байлаа. Энэ сард үнэмлэхүй их температур 12.1°C , үнэмлэхүй бага температур -22.2°C , хур тунадасны нийлбэр 2.0 мм, салхины үнэмлэхүй их хурд 18 м/секунд хүрсэн.




Хүснэгт 29. Агаарын бохирдолт, мг/м³



Бодисын нэр	Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий /SO ₂ /	0.020	208	0.090	142	0.028
Азотын давхар исэл /NO ₂ /	0.040	211	0.096	96	0.042
Тоосжилт /PM ₁₀ /	0.100	172	1.030	129	0.173
Тоосжилт /PM _{2.5} /	0.050	62	0.157	31	0.056
Нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/	10.0	413	3.625	-	1.048
Озон /O ₃ /	0.100	328	0.079	-	0.026

Мэдээллийн эх үүсвэр: Ус, цаг уур орчны хүрээлэн


Агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийг нийслэл хотын нутаг дэвсгэрт 7 харуул цэгт хэмжихэд азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2014 оны 3-р сард Улаанбаатар хотын Баруун дөрвөн замын орчимд 31 удаа, 13-р хороолол орчимд 28 удаа, 1-р хороолол орчимд 12 удаа, 32-ын тойрог орчимд 10 удаа, Офицеруудын ордон орчимд 9 удаа, Хархорин захын орчимд 6 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 32-ын тойрог орчимд 29 удаа, Баруун дөрвөн зам орчимд 27 удаа, 13-р хороолол орчимд 26 удаа, Офицеруудын ордон орчимд 22 удаа, Хархорин захын орчимд 14 удаа, 1-р хороолол орчимд 13 удаа, Ургах наран хороолол орчимд 11 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

Зураг 40. Хүхэрлэг хийн агууламж, мг/м³



Зураг 41. Азотын давхар ислийн агууламж, мг/м³Зураг 42. Тоосны /PM₁₀/ агууламж, мг/м³

10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 13-р хороолол орчимд 31 удаа, 32-ын тойрог орчимд 30 удаа, Баруун дөрвөн замын орчимд 29 удаа, Хархорин захын орчимд 27 удаа, Ургах наран хороолол орчимд 10 удаа, Мишээл экспо төвийн орчимд 2 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 17 удаа, 13-р хороолол орчимд 14 удаа стандартаас давсан байна.

Зураг 43. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м³

Хүснэгт 30. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 3-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороо- лол	13-р хороо- лол	32-ын тойрог	Офице руудын Ордон	Хар- хорин зах	Ургах наран хороо- лол
Хүхэр- лэг хий SO ₂	Дундаж	-	0.027	0.029	0.032	0.034	0.038	0.020	0.018
	Хамгийн их	-	0.040	0.088	0.053	0.047	0.090	0.038	0.034
	XXX*-с давсан хувь	-	87.0	52.0	84.0	94.0	76.0	45.0	37.0
	Хэмжилтийн тоо	-	31	25	31	31	29	31	30
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	0.029	0.077	0.037	0.053	0.037	0.033	0.034	0.032
	Хамгийн их	0.037	0.096	0.083	0.071	0.052	0.062	0.045	0.038
	XXX*-с давсан хувь	0.0	100.0	50.0	90.0	32.0	31.0	19.0	0.0
	Хэмжилтийн тоо	19	31	24	31	31	29	31	15
Нүүрс- төрөг- чийн дугуу исэл, CO**	Дундаж	-	1.555	-	1.116	1.375	-	0.903	0.291
	Хамгийн их	-	3.625	-	3.375	3.000	-	2.563	1.250
	XXX*-с давсан хувь	-	0.0	-	0.0	0.0	-	0.0	0.0
	Хэмжилтийн тоо	-	93	-	93	93	-	45	89
Тоос PM ₁₀	Дундаж	0.073	0.164	-	0.292	0.196	-	0.214	0.100
	Хамгийн их	0.129	0.267	-	0.524	0.288	-	1.030	0.361
	XXX*-с давсан хувь	10.0	94.0	-	100.0	97.0	-	93.0	33.0
	Хэмжилтийн тоо	20	31	-	31	31	-	29	30
Тоос PM _{2.5}	Дундаж	-	0.064	-	0.047	-	-	-	-
	Хамгийн их	-	0.157	-	0.092	-	-	-	-
	XXX*-с давсан хувь	-	55.0	-	45.0	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	31	-	31	-	-	-	-
Озон O ₃ **	Дундаж	0.017	-	-	0.025	0.018	-	-	0.044
	Хамгийн их	0.026	-	-	0.052	0.037	-	-	0.079
	XXX*-с давсан хувь	-	-	-	0.0	0.0	-	-	0.0
	Хэмжилтийн тоо	53	-	-	93	93	-	-	89

*- Хүлцэх хэм хэмжээ, **- CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон.

Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгт бохирдуулагч бодисын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд эрдэс фосфорын хэмжилт хийгдээгүй, хүчилтөрөгч маш бохирдолтой, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 69.7 дахин, амоны азот 70 дахин, нитридийн нэгдэл 58 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч, Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна.



Хүснэгт 31. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 3-р сард

	Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		хэмжээ	бодисын хэтрэлт	хэмжээ	бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O ₂)	≥6	-	хэвийн	-	хэмжих боломжгүй, маш бохир
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ ₅)	≤ 3	1.1	хэвийн	209.0	69.7 дахин
Нитридийн нэгдэл (NO ₂)	≤ 0.02	0.001	хэвийн	1.16	58 дахин
Амоны азот (NH ₄)	≤0.5	0.03	хэвийн	35.0	70 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	хэмжилт хийгдээгүй			

Мэдээллийн эх үүсвэр : Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

**ХОТЫН ТОХИЖИЛТ**

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2014 оны эхний улиралд Багануур, Хан-Уул дүүрэгт 812 ширхэг модыг арчилж тордон 4.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэжээ. Баянзүрх дүүрэг 0.7 км гэрэлтүүлэг хийж, нийслэлийн хэмжээнд рекламны асалт 83.8 хувь, гэрэлтүүлгийн асалт 92.2 хувь, гэрэлтүүлгийн урсгал зардалд 19.2 сая төгрөгийг зарцуулав.

Нийт 13623.8 мянган м² зам талбайг байнга болон нэг удаа цэвэрлэж, 202.7 мянган тонн хог тээвэрлэж, 219.5 мянган тонн хогийг дарж устгасан байна. Дарж устгасан хогны 20.6 хувийг орон сууцны хорооллоос, 38.7 хувийг гэр хорооллоос, 35.8 хувийг аж ахуйн нэгж байгууллагаас, 4.9 хувийг зам талбайгаас гарсан хог эзэлж байна.

Нийслэл хотод 2014 оны эхний 3 сард 26106 золбин нохойг устгаж, энэ ажилд 132.9 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 32. Тээвэрлэсэн хогны хэмжээ, мянган тонн, дүүргээр

Дүүрэг	Тээвэрлэсэн хог	хог, бүтцээр					
		Орон сууц	Гэр хороолол	ААНБ	Зам талбай	Хур хог	Бохир шингэн
Багануур	12.5	4.2	5.9	1.5	0.9		
Багахангай	2.2	0.6	0.9	0.3	0.2	0.2	
Баянгол	27.9	12.9	9.7	2.7	2.6		
Баянзүрх	28.5	7.4	12.2	4.3	1.1	3.4	0.1
Налайх	20.3	3.7	14.1	2.1	0.4		
Сонгинохайрхан	33.6	4.8	24.9	3.0	0.9		
Сүхбаатар	26.6	9.6	8.9	5.7	0.6	0.9	0.9
Хан-Уул	17.8	5.0	6.6	4.7	1.4	0.1	
Чингэлтэй	33.3	7.6	12.1	6.1	4.5	3.0	
Дүн	202.7	55.8	95.3	30.4	12.6	7.6	1.0





ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2014 оны эхний 3 сард 8.5 сая м³, аж ахуйн нэгж, байгууллагад 3.0 сая м³ цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 2.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 33. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013 он III сар	2014 он III сар	$\frac{2014}{2013} \%$
Шахсан ус	мян.м ³	13997.1	13832.0	98.8
Борлуулсан ус	мян.м ³	11142.0	11434.8	102.6
Хүн амд	мян.м ³	8377.8	8463.6	101.0
ААНБ-д	мян.м ³	2764.2	2971.2	107.5
Татан зайлуулсан бохир	мян.м ³	11061.5	11122.2	100.5
Хүн амаас	мян.м ³	7865.8	7828.6	99.5
ААНБ-аас	мян.м ³	3195.7	3293.6	103.1
Ус борлуулалтын орлого	сая төг	3904.0	4049.7	103.7
Хүн амаас	сая төг	2351.4	2375.6	101.0
ААНБ-аас	сая төг	1552.6	1674.1	107.8
Сувагжуулалтын орлого	сая төг	2221.7	2259.8	101.7
Хүн амаас	сая төг	1158.2	1153.1	99.6
ААНБ-аас	сая төг	1063.5	1106.7	104.1

Нийт борлуулсан усны 74.4 хувийг хүн амд борлуулсан ус, 25.6 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна.

Хүн амд түгээсэн цэвэр усны 96.2 хувь буюу 8.1 сая м³-ыг нь төвлөрсөн шугамаар, 314.4 мянган м³-ыг ус түгээх байраар, 2.8 мянган м³ усыг тээврээр түгээсэн байна.

Цэвэрлэх байгууламжаар 13.8 сая м³ бохир цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 11.1 сая м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Зураг 44. Борлуулсан ус, сараар, мян.м³



Зураг 45. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м³





ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2014 оны эхний улиралд нийт 106 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.5 хувиар буурчээ. Энэ оны 3-р сард гахайн үржил амьсгалын замын хам шинж өвчний нэг тохиолдол бүртгэгдэж, 330 гахай үхсэн байна.


Хүснэгт 34. Хүний үйл ажиллагаатай холбоотой осол

Ослын төрөл	2013 он	2014 он	$\frac{2014}{2013} \%$
Бүгд	123	105	85.4
Тэсэрч дэлбэрэх бодисын	2	0	0.0
Сум галт хэрэгслийн	1	1	100.0
Химийн бодисын	15	10	66.7
Бичил уурхай, нурангины	3	2	66.7
Усны осол	0	1	-
Үйлдвэрийн осол	1	0	0.0
Бусад	101	91	90.1

Гамшгийн улмаас 3 хүн амь насаа алдсан байна. Гамшгаас 113 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 36.3 сая төгрөг зарцуулсан байна.

Эхний улиралд хүний үйл ажиллагаанаас шалтгаалж 105 осол гарчээ. Тухайлбал, сум галт хэрэгслийн 1, химийн бодисын 10, бичил уурхай, нурангины 2, усны осол 1, бусад төрлийн осол 91 тус тус бүртгэгдсэн байна.

Зураг 46. Гал түймэр, байршлаар




Нийслэл хотод 2014 оны эхний 3 сард ахуйн 855 гал түймэр гарав. Гарсан гал түймрийн 7 нь Багануур, 135 нь Баянгол, 214 нь Баянзүрх, 37 нь Налайх, 114 нь Сүхбаатар, 91 нь Хан-Уул, 89 нь Чингэлтэй, 168 нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус гарсан байна.

Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилвал цахилгаанаас 152, санамсаргүй байдлаас 609, санаатай үйлдлээр 6, шалтгаан тогтоогдоогүй 65, бусад шалтгаанаар 23 гал түймэр гарсан байна. Гал түймрийн улмаас 24 хүн (үүнээс хүүхэд 5) амь насаа алдаж, 8 хүн (үүнээс хүүхэд 1) түлэгдэж гэмтжээ.

Гал түймрийн аюулаас 261 хүн, 95 байшин барилга, 1344.0 сая төгрөгийн эд хөрөнгийг аварчээ. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 575, төрийн өмчийн 230, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 50 объект өртөж, нийт 1.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Гал түймэрт 577 гэр, орон сууц, 202 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 76 машин техник өртсөн байна.



Зураг 47. Гал түймэр, шалтгаанаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2014 оны эхний 3 сард 23 барилгын зураг төсөл, ашиглалтанд хүлээн авч буй 53 барилгад хяналт тавьжээ. Мөн 6949 айл өрх, 2680 объектод үзлэг шалгалт хийж, 13096 галын зөрчил илрүүлж, 63 байгуул-лагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 662 заавал биелүүлэх албан шаардлага, 695 мэдэгдэл хүргүүлж, 15.5 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.




ГЭМТ ХЭРЭГ

2014 оны эхний 3 сард 4101 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10.1 хувь буюу 376 хэргээр өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 53.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.6 пунктээр дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 1367 хүн гэмтэж осолдсоноос 11.3 хувь буюу 155 хүн нас барж, төр ард иргэдэд 10.8 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 28.2 хувь буюу 3.1 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

2014 оны эхний 3 сард 17621 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.0 хувь буюу 681 хүнээр өссөн байна.

Зураг 48. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн 31.2 хувийг хулгайн, 26.7 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 8.0 хувийг танхайн, 7.7 хувийг залилан, 5.3 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2950 болж, 2013 оны мөн үеэс 7.1 хувь буюу 195 хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 15.2 хувь буюу 447 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 23.6 хувь буюу 696 нь согтуугаар үйлдсэн, 5.4 хувь буюу 159 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 4.8 хувь буюу 143 нь хүүхэд, 17.3 хувь буюу 511 нь эмэгтэйчүүд байна.

2014 оны эхний 3 сард хүндэвтэр хэрэг 1859, хүнд хэрэг 341, хөнгөн хэрэг 1821 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7.1-14.3 хувиар өсч, онц хүнд 80 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар буурчээ.



Хүснэгт 35. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 3 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2013 он	2014 он	Тоо	Хувь
Хүний амь	35	29	- 6	- 17.1
Хүчин	44	40	- 4	- 9.1
Дээрэм	149	176	27	18.1
Хулгай	1119	1278	159	14.2
Булаалт	51	52	1	2.0
Залилан	275	314	39	14.2
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	921	1095	174	18.9
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	255	218	- 37	- 14.5
Бусдыг амиа хорлоход хүргэх	165	139	- 26	- 15.8
Ашиглах	50	44	- 6	- 12.0
Танхайрах	339	328	- 11	- 3.2
Бусад	322	388	66	20.5
БҮГД	3725	4101	376	10.1

Хүснэгт 36. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 3 сард

дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2013 он	2014 он	Тоо	хувь
Багануур	71	68	- 3	- 4.2
Багахангай	7	3	- 4	- 2.3 дах
Баянгол	595	657	62	10.4
Баянзүрх	859	994	135	15.7
Налайх	81	90	9	11.1
Сонгинохайрхан	632	707	75	11.9
Сүхбаатар	644	629	- 15	- 2.3
Чингэлтэй	588	607	19	3.2
Хан-Уул	248	346	98	39.5
ДҮН	3725	4101	376	10.1

Хүснэгт 37. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2014 оны эхний 3 сард


дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	17	13	76.5
Багахангай	-	-	-
Баянгол	296	195	65.9
Баянзүрх	667	337	50.5
Налайх	20	10	50.0
Сонгинохайрхан	373	202	54.2
Сүхбаатар	289	130	45.0
Чингэлтэй	341	169	49.6
Хан-Уул	162	93	57.4
ДҮН	2165	1149	53.1



Хүснэгт 38. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 3 сард

дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2013 он	2014 он	2013 он	2014 он
Багануур	17	13	13	12
Багахангай	-	1	-	-
Баянгол	144	179	116	139
Баянзүрх	290	365	232	328
Налайх	9	13	5	10
Сонгинохайрхан	226	240	191	224
Сүхбаатар	188	200	142	145
Чингэлтэй	175	178	149	165
Хан-Уул	70	89	66	77
ДҮН	1119	1278	914	1100

Зураг 49. Гэмт хэргийн тоо, ангиллаар



НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР






<http://ubstat.mn>



Статистикийн ном, эмхэтгэл,
танилцуулга, сэтгүүлийг энэхүү
апп-ыг ашиглан унших боломжтой



www.1212.mn -ээс статистик мэдээллийг
интерактив байдлаар аваарай